



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/147

Бор-Өндөр сум


Утаат болон электрон тамхи түүний
дагалдах хэрэгслийг худалдах, худалдан
борлуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас жил бүр тамхины хор уршгийн талаар иргэдэд сурталчлах “Дэлхийн тамхигүй өдөр”-ийг тохиолдуулан сумын нутаг дэвсгэрт 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдах, худалдан борлуулахыг хориглосугай.

2. Утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдах, худалдан борлуулахгүй байхыг аж ахуй нэгж, байгууллагуудыг уриалж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Ц.Мөнхгэрэл), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ